

Сургаалын үндэс (Эш), түүний тайлбар (онол) хоёрыг хэрхэн шүтэлцүүлж сургалт явуулах тухай буддын сурганы онол

Доктор, профессор Н.Хавх

Түлхүүр үг: Эш, онол, шүтэн барилдлага, эх зохиол, түүний тухай,
үл харшуулах, багшаар хөтлүүлэх

Бурханы сургаалын үндэс (эш). Энэ ертөнц дээр Бурхан багшийг давж гаран ухаарсан, гэгээрсэн хүн гэж үгүй ээ. Энэ нь юу юм билээ гэхлээр Бурхан багш бүхнийг, бодит байдлыг дээд зэргээр танин мэддэгээр бусдаас онцгойрно. Тийм болохоор Бурханы сургаал номноос гажаад хэрэггүй, тэгвээс ариун сургаалаа орхино гэсэн үг. Бурхан багшийн бүтээсэн хязгааргүй үнэ цэнэтэй судар, тарнийн ном болвоос шавь нарын барьж, баримталж, мөрдөж байх дээдийн дээд, цорын ганц онол сургаал мөн болно¹ хэмээн Зонхов багш сургаж

Орчин цагийн европын шинжлэх ухааны хэлээр бол Бурхан багшийн сургаал нь ертөнцийн бүхий л үзэгдэл юмсын оршин тогтнох, үүсэн хөгжих хамгийн гүн гүнзгий бөгөөд түгээмэл хууль, зүй тогтлын талаарх туйлын үнэнд хүрсэн, дээд зэргээр нэгдэлтэй болж чадсан нэн өндөр түвшний мэдлэг, онол аж; энэ бол европын шинжлэх ухааны нэн холын, хэт ирээдүйн зорилго юм байна. Бурхан багш ухаарал, гэгээрлийн оргилд хүрснээр өнөөгийн хүний сэтгэн бодох, танин мэдэх чадварын цаад хязгаар, боломжийг даван гарч, аливаагийн дотоод мөн чанарт шууд нэвтрэн орох гоц гойд, ер бусын хүч чадал, эрдэм ухаан, увидастай болсон. Нэг үгээр, нирван дүрийг олсон хэмээдэг.

Тийм болохоор тэрээр ертөнцийг саланги тусад биш, бүхэл бүтэн байдлаар нь, түүнд үйлчлэх өдий төдий чигийн хууль, зүй тогтлыг орчин үеийн шинжлэх ухаан шиг тус тусад нь салгах биш, тэдгээрийн өөр хоорондоо шүтэн барилдаж бий болсон тэр байдлаар нь (хоосон чанарын) нээсэн, таньж чадсан гэсэн үг. Шавь нарыг бага, дунд, дээд төрөлхтөн хэмээн гурав хувааж, бүлэг тус бүрийн аливааг ойлгох чадвар, бололцоонд нь тохируулж, эрдэм ухааныг заан сургадаг тухай үүний өмнө өгүүлсэн.


Бурхан багш болвоос дээдийн дээд төрөлхтөн учраас түүний нээсэн, бүтээсэн онолын сэтгэлгээний тэр нэн өндөр түвшний номыг бусад нь бие дааж, шууд ойлгон авах нь нэн бэрх төвөгтэй; учир нь тэдний аливаагийн цаад учир шалтгаан, хууль, зүй тогтлыг танин мэдэх, ухааран ойлгох, сэтгэн бодох чадварын ялгаа нэн их. Бурхан багшийн дараа дараагийн үеийн шавь нараас түүний ном сургаалыг бие даан судлахыг зорьсон хэдий ч тус сургаалын жинхэнэ утга агуулгыг ухаарч чадахгүй байх нь олширсон аж; тнйм болохоор бурхан багшийн ойр дотны аугаа их шавь, суут мэргэдүүд дунд, бага төрөлхтөн шавь нарт нь зориулж Буддагийн зохиолд арай хялбаршуулан тайлбар хийж, нэг ёсондоо багшийнхаа сургаалыг цаашид бүтээлчээр хэрэгжүүлсэн байна.

¹Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. Т.1, СПб., 1994, 28дахь тал

Сургаалын үндэс, түүний тайлбар хоёрын шүтэн барилдлага

Сонгодог онол, тэгэх тусмаа гүн ухаан, буддын гүн ухааны сонгодог онол сургаал нь тухайн тэр судлах зүйлийн хүрээнд багтах, гүн ухааны хувьд бол ертөнцийн бүхий л үзэгдэл юмс тус бүрт нь байх шинж чанарыг шүтэн барилдуулах замаар тэдгээрт байх нийтлэг, түгээмэл, хамгийн гүний мөн чанар, учир шалтгааныг илрүүлэн тогтоож, түүнийг тайлбарлана.


Хийсвэр сэтгэлгээний тийм өндөр түвшинд бүтээгдсэн онол, сургаалыг хийсвэр сэтгэлгээний харьцангуй бага түвшинд шат дараалан буулгаж; хүмүүсийн өдөр тутмын амьдрал практик, улмаар мэдрэхүйн таван эрхтэнд өртөх тухайн тодорхой үзэгдэл юмстай сайтар холбож эс өгвөөс бага, дунд төрөлхтөн буюу ердийн хүмүүс ухаарахад бэрх, хоосон утга агуулгатай мэт ойлгогдоно; тэгээд ч түгэн дэлгэрэх замд нь саад тотгор ихээр бий болно; олныг, шавь нарыг ухааруулах, гэгээрүүлэх, тэдний зовлонг нимгэлэх үүд хаалга хаагдах замд орно. Ингэхлээр буддизмын сонгодог онолыг амьдралтай холбож, газар дэлхий дээр буулгах нь гарцаагүй зүйл; гарцаагүй төдийгүй бололцоотой зүйл аж. Учир нь онол, түүний тайлбар хоёр нь шалтгаан, үрийн холбоотой аж¹. Дээрх санааг зургаар илэрхийлвээс (зураг №1)



Зураг №1

Буддын сургаалын үндэс, түүний тайлбар хоёр шүтэн барилдах зүй тогтлыг зураг №2 дээр тайлбарлах нь илүү ойлгомжтой болно; үүний тулд "ахмад үе"-ийн оронд сургаалын үндсийг, "залуу үе"-ийн оронд үндсийн тайлбарыг тавьна. Буддын гүн ухааны сэтгэлгээгээр бол үндэс нь билиг нь давамгайлсан, тайлбар нь арга нь давамгайлсан тэнцвэрт бус тогтолцоо; тайлбар нь үндсийнхээ агуулгыг илүү ихээр баяжуулна; үндсийн баяжигдах, амьдрал практиктай холбогдох эрч хүч ийнхүү болно (зураг дээрх доод талын сум); үндэс нь болохоор тайлбар хийх зүг чигийг заана (зураг дээрх дээд талын сум); үндсийн агуулгыг хичнээн задаллаа ч, баяжуулан дэлгэрүүллээ ч, амьдрал практиктай холболоо ч, энэ бүхэн үндсийн агуулгаас, зарчмаас гарах учир угүй гэдгийг зааж зурж өгнө. Тайлбар

¹Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. Т.1, СПб., 1994, 30 дахь тал



Зураг №2

нь хэсэг, үндэс нь бүхэл; тайлбар нь элемент, үндэс нь системийн шинж; тайлбар нь юмсын шүтэн барилдалгаанд орохын өмнөх шинж, үндэс нь шүтэн барилдаж бий болсон шинж буюу хоосон чанар. Үндэст тайлбар хийж байгаа нь энэ гээд түүнийг тайлбарт тэр чигээр нь уусгачихаж болохгүй (зураг дээрх ахмад үе талын 5). Хичнээн ч тайлбарлагдлаа тайлбарлагдлаа гэхэд үндэс үндэс чигээр, тайлбарлагдсан үндэс байх (зураг дээрх ахмад үе талын 2); тайлбар хийхдээ үндсийг чанд баримталж байгаа нь энэ гээд үндсийн агуулгыг тэр чигээр нь хураангуйлсан чиг байдлаар юм уу дахин давтах зэргээр тайлбарыг үндэс болгон хувиргаж (зургийн залуу үе талын 5) бас болохгүй; энэ хоёр тохиолдлын аль аль нь бурханы сургаалын, ер нь аливаа шинжлэх ухааны хөгжлийг хөгжил биш болгоно; эхний тохиолдолд хөгжлийг эмх цэгцгүй байдалд оруулна, улмаар задрал бутралаар дуусгана; хоёр дахь тохиолдолд тэрхүү хөгжлийг зогсонги царцангиар бас дуусгана; тайлбар үндэс хоёрыг зөвөөр шүтэн барилдуулваас үндэс нь хичнээн ч задаргаанд орж тайлбарлагдлаа ч билиг нь аргаасаа давамгайлсан мэдлэгийн тогтолцоо буюу үндэс хэвээрээ (зургийн ахмад үеийн 2, 3); тайлбар нь үндсийн гол агуулгыг хичнээн чанд баримталлаа ч арга нь билгээсээ давамгайлсан мэдлэгийн тогтолцоо буюу тайлбар хэвээрээ байна (зургийн залуу үеийн 2, 3); ингэж чадсанаар буддын, ер нь аливаа шинжлэх ухааны онол сургаал зөв замаар, эрч хүчээ сааруулахгүйгээр урагш ахин дэвшиж хөгжих зүй тогтолтой аж. Сургаалын үндэстэй зөв шүтэн барилдуулсан тайлбарыг судалваас үндсийн агуулгыг ухан ойлгож чадна (зургийн залуу үе талын 2,3).

Энэ тухай Зонхова багш "Хэрэв тайлбар нь яахын аргагүй хийгдсэн байваас аугаа их сургаалын үндсийг ойлгоход тус дөхөм болж чадна"¹ хэмээн сургасан байна. Хэрэв тайлбар хийж байгаа нь энэ гээд үндэс үндсийнхээ агуулгын хүрээнээс хальж, халих халихдаа түүний гол агуулгыг бүүр алдуулваас тэр тайлбар нь үндсийг ойлгоход тус дэм үл болно; харин чиг шавь нарыг төөрөлдүүлнэ (зургийн ахмад үе талын 5, залуу үе талын 1).

Энэ тухай "Их бодь морийн зэрэг" зохиолд "Тайлбарыг хичнээн хүч хөдөлмөр заран байж уншлаа ч энэ бүхэн нь аугаа их сургаал, онолын утга агуулгыг ойлгон авахад тус нэмэр болохгүй, эсвэл уншсан зүйл чинь тэрхүү сургаал номтой тэрсэлдэн харшилдваас уг тайлбарыг таягдан хая"¹ хэмээн айлдсан байна. Сургаалын үндэс, тайлбар хоёр дээр өгүүлснээр европын гүн ухааны хэлээр бол зөрчлийн диалектикаар; буддын гүн ухааны хэлээр арга билгийн шүтэн барилдалгаагаар төв үзлийн зүй тогтлоор холбогдоно; үүнийг эс ойлговоос бурханы сургаал нь онол буюу үндэс суурь, түүнтэй бараг холбоогүй тайлбар гэсэн хоёр хэсэгт хуваагдана; эхнийхийг нь судартнууд (зураг №2-ын ахмад үе талын 1) хоёр дахийг нь тайлбартнууд (зураг №2-ийн залуу үе талын 1) хэмээн нэрлэж ирсэн түүхтэй юм байна; энэ нь буддын ном, онол сургаалд итгэл алдагдуулах, эсвэл тэрхүү сургаалын агуулгыг гажуудуулах осолтой аж.

Аливаагийн хөгжлийн оршин тогтнох үндэс бол

¹ Мөн тэнд. 29 дэх тал

1. зөвхөн арга ч биш
2. зөвхөн билиг ч биш
3. арга, билиг хоёулаа чиг биш
4. харин арга, билиг хоёрын шүтэн барилдалга хэмээн буддын гүн ухаанд номлоно. Үүнийг сургаалын суурь, тайлбар хоёр дээр буулгаваас: Бурханы шашны онолын хөгжих, оршин тогтнох үндэс гэвэл,


1. зөвхөн тайлбар (онол) ч биш
2. зөвхөн үндэс чиг биш
3. тайлбар (онол), үндэс хоёулаа чиг биш
4. харин тайлбар (онол), үндэс хоёрын шүтэн барилдалга хэмээн бууна.

Бурханы шашны онол сургаал нь өөр хоорондоо холбоогүй үндэс, тайлбар хэмээх хоёр хэсгээс бүрдэнэ гэх үзэл нь угтаан, тэрхүү онол сургаал нь үндэс, тайлбар хоёроос зэрэг бүтнэ хэмээн үзсэн хэрэг. "Буддагийн онол сургаалд бүхэлдээ ямар ч тайлбар хэрэггүй, тайлбар нь чиг тусдаан, түүнээс саланги тусдаан байна; ер нь чиг сургаал номыг үндэс, тайлбар хэмээх саланги тусдаан байх хоёр хэсгээс бүтнэ хэмээн үзвээс шавь нарыг судар, тарнийн сургаал, тэдгээр тайлбар хоёрын аль алинд итгэх итгэлгүй, бишрэх сүжиггүй болгоно. Ингэснээр бурхан багшийн сургаалаас татгалзаж, муу үйл үрийг ихээр хуримтлуулна"¹ хэмээн "Их бодь морийн зэрэг"-т өгүүлжээ. Орчин үеийн аль ч шинжлэх ухааны мэдлэг буддын онол, сургаал шиг өндөр түвшинд хүрч, ертөнцийг "сурах юмгүй болтол нь таньсан" туйлын дээд, туйлын үнэнд хүрч очсон биш хэдий ч дээр ярьсан бүхэн нь орчин үеийн европын шинжлэх ухааны сургаалд ч нэгэн адил үйлчлэх, баримтлагдах зүйл байхаар төсөөлөгдөнө. Бараг орчин үеийн европын шинжлэх ухааны аль ч салбар өөрийн гэсэн сонгодог онол сургаалтай байх агаад тэрхүү онол сургаал нь гарамгай суут буюу ердийн бие хүнээс хол давсан сэтгэн бодох чадвартай хүмүүсийн оюун ухаанаар бүтээгдсэн байдаг. Байгалийн шинжлэх ухааны салбарт л гэхэд Дарвины байгалийн шалгарлын хууль онол; физикийн салбарт Эйнштейний харьцангуйн онол, гүн ухааны салбарт Гегелийн диалектик, химийн шинжлэх ухааны салбарт болохоор Менделеевийн үелэх системийн хууль, Зөвлөлт Оросын сэтгэл судлалын салбарт Д.Н.Узнадзегийн төгс ухамсарын онол ч юм уу, эсвэл А.М.Леонтьевын үйл ажиллагааны онол ч юм уу; дээр өгүүлсэн сонгодог онолыг бүтээсэн гоц ухаантай хүмүүс нь ердийн бие хүнээс хол давсан сэтгэн бодох чадвартай; тэд ердийн хүмүүсийн таньж чадахгүй зүйлийг танина; хүрэхгүй мөн чанарт хүрч очно; тэд ердийн хүмүүс агуулгыг нь шууд ухаарахын аргагүй тийм онол сургаалыг бүтээнэ; тийм болохоор ердийн хүний түвшинд тохируулан, буддын гүн ухааны хэлээр бол дээд төрөлхтний бүтээсэн онол сургаалыг бага буюу дунд төрөлхтөнд хүргэх зорилгоор сонгодог онол сургаалын агуулгыг, гарамгай, суут хүмүүсийн ном зохиол, эх бичгийг задлан хялбарчлан тайлбарлах, энэ тухай суралцагсад зориулан гарын авлага, ном товхимол гаргах нь зайлшгүй зүйл. Орчин үеийн сургалтанд "эх зохиол", түүний тухай ном бүтээл "эх зохиолоос нь уншина", "тухайгаас нь уншина" гэсэн чиг ойлголт бий. Орчин цагийн сургалт дахь "эх зохиол", "эх зохиолын тухай" хоёрын уялдаа авцалдаа, харьцаа хамаарал нь буддын сургалтан дахь "сургаалын үндэс", "түүний тайлбар"-тай эгээ нэг байх учиртай (зураг №2-ийн "ахмад үе тал нь "эх зохиол", "залуу үе" тал нь "түүний тухай ном зохиол болно"). Сургалтыг зөвхөн эх зохиолоор. явуулж эс болно; учир нь суралцагсад эх зохиол дахь сонгодог онол сургаалын агуулгыг сайтар ухаарч үл чадна, сургалт сургалт биш болно; сургалт зөвхөн "эх зохиолын тухай"-гаар явж үл болно; учир нь "тухай" нь хичнээн чиг

сайн болсон байлаа ч, эх зохиолын өндөр түвшний агуулгыг төгс төгөлдөр гаргаж эс чадна; суралцагсад тэрхүү агуулгыг бүрэн гүйцэт ухаарч эс чадна; хэрэв "тухай" нь муухан шиг бол, эх зохиолын агуулгыг бүрхэгдүүлсэн, улмаар гажуудуулсан бол "тухай"-гаар сургалтыг явуулж бүүр ч болохгүй; эхний тохиолдолд сургалтын агуулга зогсонги царцанги байдалтай болно; хоёр дахь тохиолдолд сургалтын агуулга задрал бутралд орно, эрээвэр хураавар үзэл, тайлбаруудын цуглуулга болно; сургалт дээрхийн нэгэн адил сургалт биш болно.

Хэрэв сургалтыг хоорондын уялдаа авцалдаа муухан, шүтэн барилдалгаагүй, саланги тусдаан "эх зохиол "түүний тухай" хоёроор зэрэг явуулбал тэрхүү сургалтын нэг хэсэгт зогсонги царцанги, нөгөө хэсэгт нь задрал бутрал зэрэгцэн лавширч; бас л сургалт биш болно.

Сургалтыг зөв явуулах гол зам гэвэл эх зохиол, "тухай" хоёрыг зураг №2-ийн аль аль талын 2,3-аар зохион байгуулахад бий. Арга, билгийг шүтэн барилдуулах, эс барилдуулах талаасаа бол аливаагийн хөгжил тойргоор, шулуун шугамаар, спиралиар явдаг тухай сонгодог гүн ухааны сургаал бий (зураг №3).



Зураг №3

Зөвхөн эх зохиолоор явуулваас сургалт ямар нэгэн хэмжээгээр зогсонги царцангид орно (зургийн "б"); зөвхөн муухан бичсэн "тухай"-гаар явуулваас сургалтын агуулга эрээвэр, хураавар, улмаар нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн тайлбар, үзэл санаагаар дүүрнэ; задрал бутралаар дуусна (зургийн "а"); хэрэв эх зохиол, түүний сайтар хийсэн "тухай" хоёрыг зохистойгоор хослуулан явуулваас сургалт зөв замаар, спиралиар урагш

ахин дэвшиж, өмнөх шатнаасаа аль шилдэг сайн зөв үзэл, онолын санааг уламжлан авч, түүнийг шинэ шинэ агуулгаар баяжуулан байж урагш ахин дэвшинэ (зургийн "в").

Сургаалыг багшаар хөтлүүлж хялбар ойлгох эрдэм.

Сургаалын үндэс, түүний суурь тайлбарууд нь ном эрдэмд суралцах шавийн үйл ажиллагааг чиглүүлэх гол номууд; шавь нар дадлага туршлага нимгэнээс болж, дээрх үндэс тайлбарт хичнээн чиг шамдан орлоо ч, түүний жинхэнэ, гол агуулгыг авч чадахгүйд хүрнэ; хүрлээ ч ихээхэн хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулна.

Харин багшаар хөтлүүлвээс, заалгаваас тэрхүү үндэс тайлбарыг хялбар, түргэн ухааран ойлгоно¹. Хэрэв зөв хийсэн сайтар тайлбаргүй авбаас энгийн бие хүн, дунд, бага төрөлхтөн болох шавь нар тэр гарамгай, суут хүмүүсийн бүтээсэн, туурвисан онол сургаалыг зөв ойлгож чаддаггүй тухай дээр өгүүлсэн; харин сайн "тайлбар"-тай байхад багшаар заалгах, хөтлүүлэх

¹Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. Т.1, СПб., 1994, 30 дахь тал

шаардлага яагаад гарах учиртай юм бол? Багш, шавь хоёр нь нэг түвшний, гол төлөв ердийн бие хүн, дунд төрөлхтөн хэдий ч, багш нь шавиас түрүүлж ухаарал гэгээрлийн зохих түвшинд хүрсэн эрдэм ухааныг сурч эзэмшсэн, сурч боловсрох ажил хөдөлмөрийн арга ухаан, туршлага, дадлагатай болчихсон; дээр нь .бусдад, шавь нарт эрдэм ном зааж зурах ухаанд мэргэжсэн нэгэн; тийм болохоор шавь хүн багштай байваас, багшаар ном эрдэм заалгаж байваас "үндэс", "тайлбар"-ын агуулга, тэдгээрийн агуулгын авцалдаа, шүтэлцээ зэрэгт эс төөрөлдөнө. Түүнийг гажуу ташаа, дутуу хазгай үл ойлгоно; түүнийг харьцангуй бага хугацаанд, бага хөдөлмөр зарж, ухааран, сурч эзэмшинэ.

Буддын гүн ухааны хэлээр бол багш нь билиг, шавь нь арга; сургалт зөвхөн багшийн сонирхлоор явбаас яваа яваандаа зогсонги царцанги байдалд орно; учир нь багш хүний ясны сонирхол бол зөвхөн "үндэс"-ийг л голлон барих, "тайлбар"-ыг бол "үндэс"-тэй шууд холбож түүний гол агуулгыг л шавь нартаа олгоход бий; сургалт зөвхөн шавь нарын сонирхлоор явах учиргүй; хэрэв тэгвээс сургалтын агуулга ямар нэгэн зангилагаагүй болж, задрал бутралаар дуусах ч тал бий; учир нь шавь нар нь аливаагийн цаад учир шалтгааныг өөр өөрийнхөөрөө ухааран ойлгох ясны сонирхолтой; нэг үгээр хэлэхэд багш нарын ясны сонирхол гэвэл "үндэс"-ийг дагнан барих; шавь нарынх болохоор "тайлбар"-ыг хэтрүүлэн хэрэглэхэд бий.

Сургалт билиг болох багш, арга болох шавь хоёрын үзэл бодол, эрдэм ухаан, боловсрол мэдлэг, ашиг сонирхол, сэтгэл санаа, сэтгэн бодох түвшин, үйл ажиллагаа зэргийн шүтэн барилдалгаар урагш ахин дэвшиж хөгжинө; мөн цагаа болохоор уруудна, дахин дэвшинэ; багш нь шавь нарынхаа суралцах үйл ажиллагааг зүглүүлнэ, чиглүүлнэ, замыг нь зааж өгнө, ер нь сургалтын чиг болно; шавь нь болохоор сургалтын болон багшийнхаа үйл ажиллагааг эрчимжүүлнэ; учир нь шавь нь залуу хүн болохоор аливаагийн цаад учир шалтгааныг урьд өмнө хэн ч хийгээгүй, хөндөөгүй; цоо шинээр харах, ухаарах, ер нь өөр өөрсдийнхөөрөө ойлгох, тайлбарлах чин эрмэлзэл, тэмүүлэлтэй; багш хүн болохоор наад зах нь шавь нарын эрмэлзэл тэмүүллийг мэдрэх, цаад зах нь тэдний сонирхол, тэмүүллийг тооцож хичээлийн агуулга, заах арга зэргээ байнга сайжруулах; сургалт, хичээлийнхээ агуулгыг цаг алдалгүй сайжруулах, боловсронгуй болгохоос өөр замгүй байдаг аж; үүний тулд багш нь багш шиг. Шавь нь шавь шиг байх учиртай аж; энэ бүхэн нь бас биеэ даасан эрдэм ухаан болдог юм байна.

Буддын сурган хүмүүжүүлэх ухаанд "сургаалыг багшаар хөгжүүлж хялбар ойлгох"-ыг нэгэн зүйлийн эрдэм ухаан гэсний учир ийм юм байна.

*Сургаалын бүрэлдэхүүн хэсгийг сөргөлдүүлэн үгүйсгэх
гэмийг хаах эрдэм ухаан.*

Ертөнцийн тухай, түүний оршин тогтнох зүй тогтлын тухай, хүний амьдралын утга учир буюу зовлонгийн тухай, түүний шалтгааны тухай, түүнийг арилгах арга замын тухай гэх мэт буддын гүн ухааны сургаал нь тэрхүү объектив ертөнц, хүний субъектив ертөнц хоёр лугаа пирамидын тогтолцоотой байдаг тухай үүний урьд дэлгэрэнгүй өгүүлсэн (зураг №1).

Бурханы сургаал, ном, онол нь хичнээн ч өөр өөр түвшнийх, хичнээн ч өөр өөр чиглэлээр дотроо салбарлалаа ч, салбарласан чиг байлаа, тэд нэгэн бүхэл хэсэг болно; нэг нь нөгөөгөөсөө урган гарна, өөр хоорондоо шүтэн

барилдана; ерөнхий сургаалынхаа тогтолцоонд тэдний нэг нь арга, нөгөө нь билиг чигийн үүрэг гүйцэтгэнэ; тэдгээрийг яг энэ байдлаар нь, уялдаа холбоонд нь авч үзэхийг үүний өмнө өгүүлснээр, буддын гүн ухаанд, сурганы онолд "сургаал номын агуулгыг дотор нь үл харшилдуулах эрдэм ухааны гайхамшиг" хэмээн томьёолсон хэрэг.

Харин энд сургаал номын бүрэлдэхүүн хэсгийг сөргөлдүүлэн тавьж нэгийг нь зөв, нөгөөг нь буруу; нэгийг нь хэрэгтэй, нөгөөг нь хэрэггүй гэх мэтээр ялгаварлан, алагчлан үзэх нь нэн буруу, нүгэлт явдал, угтаан бурханы номноос татгалзсан, түүнд суралцахаас ухарсан явдал гэдгийг тайлбарладаг байна.

Энэ тухай "Их бодь мөрийн зэрэг" зохиолд "энэ бүх нарийн уялдаа, шүтэлцээг үл ухааран, тэдгээр бүрэлдэхүүн хэсгийн зарим нь ухаарал, гэгээрэлд хүрэх зам мөн, заримыг нь болохоор тэрхүү ухаарал, гэгээрэлд хүрэхэд саад тотгор болно; ер нь тэдгээр бүрэлдэхүүн хэсгийн нэг хэсэг нь зөв, нөгөө нь буруу; зүй нь гэхэд их хөлгөн, бага хөлгөн хоёрын нэгэнд нь л суралцвал зохино; нөгөөд нь хэрэггүй гэх юм уу, "Үүнд л бодисадва нар суралцах хэрэгтэй, нөгөөд нь огт хэрэггүй" гэх мэтээр ойлгох нь, ойлгосныхоо дагуу явах нь Бурханы тэр туйлын үнэн зөв сураалаас татгалзсан хэрэг"¹ хэмээн сургасан байна. Цааш нь энэ ном нь зөв, энэ нь буруу гэж ярих нь бурхан багшийн сургаалаас татгалзсан хэрэг.

Үүнд нь дээд төрөлхтөн шавь нар суралцвал зохино, түүнд нь зөвхөн бага төрөлхтөн шавь суралцах ёстой хэмээн үзвээс энэ нь багшийн сургаалаас татгалзсан явдал бас мөн.

Үүнд нь зөвхөн дунд төрөлхтөн шавь нар суралцваас зохино хэмээвээс тэр нь Бурхан багшийн сургаалаас мөн л татгалзсан хэрэг болно.

Үүнийг тайлбарлах нь дээд төрөлхтөн шавь нарын эрхлэх ажил биш гэвээс, тэр нь дахиад л Багшийн сургаалаас татгалзсан хэрэг болж хувирна. Багшийн сургаалаас татгалзах нь нэн урхагтай үр дагавартай². Хэрэв бага хөлгөнөөс татгалзвал номонд суралцах эрдэм ухааны нүгэл буяны талаар ямар ч төсөөлөлгүй, дунд, их хөлгөнд орно; бэлтгэл дутагдаж, дунд, дээд хөлгөний ном, суралцаж чадахгүйд хүрч, тэр хүний хувьд ухаарах, гэгээрэх зам үүрд хаагдана; тэрээр зовлонгоос насан туршдаа үл сална, нүтэлт амьдралыг туулна гэсэн үг.

Хэрэв бага хөлгөний номыг үзсэн чиг гэсэн дунд хөлгөн татгалзваас тэрээр хүний амьдралд гүйцэтгэх үүргийн тухай, зовлон, ухаарал, гэгээрлийн амьдрах эрч хүч, энергийг олох уг сурвалж болох уг сурвалж болох тухай; зовлонгийн нэр төрөл, хүний амьдралын өгсөх уруудах шатанд тэдгээрийн гүйцэтгэх үүргийн ялгааны тухай ямар нэгэн мэдлэг, төсөөлөлгүйгээр, их хөлгөнд орохыг санаархана; орлоо чиг гэсэн угтвар нөхцөл, суурь дэвсгэр дутагдаж, тэр хүний ухаарал гэгээрэл бага хөлгөнөөр шувтран дуусна; тэрээр зовлонгоо нимгэлж хэзээ ч үл чадна; буян хураахаас нүгэл иххураана; сайнаасаа муу үйлийг илүү ихээр хийнэ; бүхий л амьдрал нь ийм л байдлаар дуусна гэсэн үг.

Хэрэв хэн нэгэн хүн бага, дунд хөлгөний номыг сайтар үзэж дууссан чиг гэсэн дээд хөлгөнд эс орвоос, орохыг хэрэггүй юм гэж

¹Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения.Т.1,СПБ.,1994, 30 дахь тал

²Мөн тэнд

үзвээс тэрээр зовлонгийн шалтгаан муу сэтгэл болох тухай; аливааг танин мэдсэнээр муу сэтгэлээс, мунхагийн харанхуйгаас гарч болох тухай; бодь сэтгэлийг олж, нүглээс, зовлонгоо нимгэлж улмаар тэрхүү зовлон, нүглээс салах зүй тогтол бий тухай, бодь сэтгэлийг олох гол арга зам гэвэл 8 зөв зам мөр болох тухай; ухаарч гэгээрсээр байгаад энгийн хүний оюун ухаан, сэтгэн бодох чадвар, ёс суртахууны дээд хязгаарыг давж, билгийн чанад хүрдэг тухай, улмаар Бурхан багшийн шинж буюу нирванд хүрдэг тухай наад захын мэдлэггүй, цаашилваас өөрөө түүнд хүрч орох үүд хаалгагүй болно; тэрээр хэзээд ч төгс ухаарч гэгээрч, нүгэл, зовлон, муу сэтгэлээс эгнэгт салж жаргалд, амгаланд хүрч чадахгүй болно гэсэн үг.

Багшийн сургаал номын бүрэлдэхүүн хэсгийг алагчлан үзэж, нэгийг нь орхиж, нөгөөд нь өрөөсгөлөөр орвоос тэр нь тухайн хүнд жаргалаасаа илүү зовлон авчирна, тийм байдлаас гарч эс чадваас тэрээр насан туршдаа нисванис, муу сэтгэл буюу сэтгэлийн хөөрөлд хөтлөгдөнө, хөөгдөнө; амьдрал нь мөнхийн эсэргүүцэл, тэмцэлтэй байх болно, гэхдээ насан туршдаа ялагдан дийлдэж, амар тайван байдал, жаргалыг эс үзнэ гэдгийг нэн сайн ухаарахыг; тийм байдлаас гарах эрмэлзэл төрөх, энэ чигийн сэтгэлийн тэнхээ олохыг "сургаалын бүрэлдэхүүн хэсгийг сөргөлдүүлэн үгүйсгэх гэмийг хаах эрдэм ухаан; их гэмт явдал өөрөө хаагдан одохын эрдэм" гэж томьёолсон аж.

Буддын сурганы дээр өгүүлсэн бүхэн орчин цагийн шинжлэх ухааны сургалтанд чиг гэсэн байх ёстой болов уу. Хэрэв сэтгэл судлалын шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсгийн нэгийг нь сайн, хэрэгтэй, түүнд суралцвал зохино; нөгөөг нь муу, хэрэггүй, түүнээс хол хөндий явбал зохино хэмээн үзвэл (зураг №1-г эргэж үзнэ үү) лав тэр хүн сэтгэл судлалын төгс сайн боловсролтой хүн байж чадахгүй, зүйрлэвээс сэтгэл судлалын шинжлэх ухаанд "сонгодог гүн ухаан, түүний арга зүй бол хэрэггүй зүйл, сэтгэл судлалыг шинжлэх ухааныг гүн ухааны боолчлолоос чөлөөлбөл зохино" хэмээн үзвээс (тийм үзэл сэтгэл судлалыг шинжлэх ухаанд байсан байна)¹, тэгээд түүгээр явбаас сэтгэл судлалын онол л гэхэд сонгодог ухааны түвшинд хэзээд ч очихгүй; бусад шинжлэх ухаантай холбогдохгүй, тэдгээрийг өөр хооронд нь шүтэн барилдуулах бололцоогүй, холбохын аргагүй юм болно; сэтгэл судлалын гүн ухаан хэмээх салбарын гүн ухааныг бий болгох ямар ч бололцоогүй юм болно.

Сэтгэл судлалын ерөнхий онол, салбар сэтгэл судлалын онол гэхээр нэг нь нөгөөгөө ор тас үгүйсгэсэн, зүсэн бүрийн, өрөөсгөл, буддын гүн ухааны хэлээр бол зөвхөн арга талыг, эсвэл зөвхөн билиг талыг туйлшруулсан эрээвэр хураавар үзэл урсгал, чиглэлүүдийн цуглуулга болон хувирна; тэгээд тэдгээр нь цагийн шалгуурыг эс давна, хөгжил нь сүүлдээ буруудна; эмпирик сэтгэл) судлал л гэхэд онол арга зүйн удирдлага чиглэлгүй, сорил туршилтын аргаар олсон баримт фактын сав болж хувирна; нэг үгээр хэлэхэд дээр ярьсан бүхэн нь "онолгүй практик сохор" гэдгийг гэрч, нотолгоо баталгаа, аргын туйлшрал тухайн тогтолцоогоо задрал бутралаар хөнөөнө гэдэг болно, сэтгэл судлалын шинжлэх ухааны хөгжил задрал бутралаар дуусна.

Дээрх тохиолдолд сэтгэл судлалын мэргэжилтэй эрдэмтэн мэргэдүүд нь мэргэжлийн хүрээнээс халин аливааг ухаарах, сэтгэн бодох чадваргүй, Д.Нацагдоржийн туурвисан "Хуучин хүү" лүүгээ "хөмөрсөн тогоон доторх ертөнцөөс" өөр ертөнцийг үл мэднэ, тэнгэрийн

¹Б.Туяа. Бие хүний сэтгэл судлал зүй, сэтгэлийн өрнөдийн онол, гол төлөөлөгчид, УБ, 2003

хаяанаас цааш газаргүй хэмээн сэтгэнэ, сэтгэл судлал хэмээх мэргэжлийн явцуу хүрээнд уялдана; уг хүрээний гадна байгаа бодит байдлыг нүд нь харахгүй, ухаан нь ойлгохгүй. Буддын гүн ухааны хэлээр бол "хөмөрсөн тогоо"-ны гаднах ертөнцтэй харьцах харьцаанд бол мунхагийн харанхуйгаар хандана, улмаар зовлон нь нэмэгдсээр байх болно.

Хэрэв сэтгэл судлалын шинжлэх ухаанд зөвхөн онол л хэрэгтэй, эмпирик сэтгэл судлал гэж байх шаардлагагүй гэх юм уу, дээд түвшний онол нь байхад заавал ч үгүй түүнээс дээгүүр түвшний онолтой байх шаардлагагүй хэмээн үзвээс сэтгэл судлал нь амьдралаас тасархай, хоосон агуулгатай, хийсвэр сэтгэлгээгээр бий болсон мэдлэгийг тогтолцоо болон хувирна; сэтгэл судлалын хөгжил н яваа яваандаа зогсонги царцангиар дуусна.

Сэтгэл судлал төдийгүй, европын аль ч шинжлэх ухааны сургаал нь бүхэлдээ хүнд зөвхөн мэдлэг олгох, түүнийг ухааруулахад чиглэгдэхээс биш, буддын ухааны сургаал шиг сэтгэлийг зөөлрүүлэх, сэтгэлийн бузрыг арилгах, сэтгэлийн хөөрөл, саатал, хөдөлгөөнийг ухааны жолоодлогод оруулах, ухаанчлагдсан сэтгэлийг бий болгох чигийн сургалт хараахан биш; тийм болохоор буддын хийгээд европын ухааны сургалтыг хүмүүст сэтгэлийн хүмүүжил, боловсрол олгох талаас нь харьцуулахын аргагүй шахуу.

Ашигласан материал

1. Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. Т. I, СПб., 1994,
2. Н.Хавх. Буддын сурган сэтгэл судлал, хүмүүжлийн гүн ухаан. V. 2006
3. Б.Туяа. Бие хүний сэтгэл судлал зүй, сэтгэлийн өрнөдийн онол, гол төлөөлөгчид, УБ, 2003